

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛТГАЛТЫН ТАЙЛАН
/ТОВЧЛОЛ/

2019.06.28

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “ИНЕГ-ын харьяа НХҮА-ны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 19/12 дугаар удирдамжийн хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийг дуусталх хугацаанд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Цацрал, нисэхийн аюулгүй ажиллагааны менежер П.Батсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан 19/12 дугаар удирдамжийн хүрээнд НХҮА-ны 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн гэрээний болон төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, цалин хөлсний бодолт, олголт, бусад асуудал зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

НХҮА-ны үйл ажиллагаа нь ИНД 172 дүрмийн шаардлагуудын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн Үйл ажиллагааны зааврын дагуу явагдаж байгаа ба байгууллагын дотоод хяналт, чанар баталгаажуулалтын үйл ажиллагаа хэвийн байна.

Тус алба нь эрсдэлийн үнэлгээг тогтмол хийдэг, мөн НААХЗА-ны байцаагчийн дүгнэлтийн биелэлт 92.8% гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэж дүгнэж болохоор байна.

Захиргааны мэргэжилтэн болон нягтлан бодогчийн хайхрамжгүй байдлаас цалинтай чөлөө авсан 26 ажилтанд хоолны мөнгийг илүү олгосон.

Мэргэжлийн зэргийн шалгалт өгөөгүй ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангаагүй ажилтан одоог хүртэл байсаар байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу илүү олгосон цалин хөлсийг ажилтнуудаас суутгаж байгаа боловч нэг ажилтнаас суутгаагүй байна.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар 5 зөвлөмж хүргүүлсэн.

ДОТООД АУДИТЫН АЛБА